

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН



2025 он



Агуулга

Удиртгал

- 4 Гүйцэтгэх захирлын мэндчилгээ
- 5 Тогтвортой хөгжлийн тайлангийн тухай

1. Бидний тухай (GRI 2-1 – 2-6)

- 7 1.1 Байгууллагын ерөнхий мэдээлэл
- 7 1.2 Алсын Хараа, Эрхэм зорилго, Үнэт Зүйлс
- 8 1.3 Оролцогч талуудын тухай

2. Тогтвортой хөгжлийн стратеги (GRI 2-22 – 2-23)

- 10 2.1 Бидний оролцоо
- 12 2.2 Тэргүүлэх БОНЗ сэдвүүд

3. Байгаль орчин (GRI 300 Series)

- 15 3.1 Хүлэмжийн хийн ялгарал
- 16 3.2 Ногоон санаачилгууд
- 20 3.3 Нөөцийн хэмнэлт

4. Нийгэм (GRI 400 Series)

- 22 4.1 Хүний нөөц
- 23 4.2 Ажилтнуудын хөгжил, сайн сайхан байдал
- 24 4.3 Хөдөлмөрийн аюулгүй байдал
- 24 4.4 Санхүүгийн боловсрол ба санхүүгийн хүртээмж
- 28 4.5 Тогтвортой санхүүжилт
- 29 4.6 Олон нийтэд мэдээлэл түгээх

5. Засаглал (GRI 2-9 – 2-21, GRI 205)

- 33 5.1 Төлөөлөн удирдах зөвлөл
- 34 5.2 Удирдлагын баг
- 35 5.3 БОНЗ-ын Бодлого ба хэрэгжилт
- 36 5.4 Ил тод байдал ба тайлагнал
- 38 5.5 Байгууллагын дотоод чадавхи
- 39 5.6 Мэдээллийн аюулгүй байдал
- 39 5.7 Эрсдлийн удирдлага

6. GRI Content Index

- 40 6.1 GRI 2 - Ерөнхий мэдээлэл
- 40 6.2 GRI 3 - Тэргүүлэх сэдвүүд
- 40 6.3 GRI 200 - Эдийн засаг
- 41 6.4 GRI 300- Байгаль орчин
- 41 6.5 GRI 400 - Нийгэм
- 41 6.6 GRI FS - Санхүүгийн үйлчилгээний салбарын тусгай үзүүлэлтүүд

Удиртгал



Гүйцэтгэх Захирлын Мэндчилгээ



Богд Банк нь урт хугацааны үнэ цэнийг хэрэглэгчид, ажилтнууд болон нийгмийнхээ төлөө бий болгоход хариуцлагатай банкны үйл ажиллагаа болоод тогтвортой өсөлтийг зайлшгүй шаардлагатай гэж үздэг билээ. Бидний Байгаль орчин, Нийгэм, Засаглал (БОНЗ)-ын бодлого нь илүү тогтвортой, хүртээмжтэй ирээдүйг цогцлоохын төлөө гаргаж буй шийдвэр бүрийг чиглүүлж өгдөг юм.

2025 онд бид GHG Protocol стандартын дагуу хүлэмжийн хийн ялгарлыг анх удаа бүтэн жилийн хэмжээнд бүрэн тооцлоо. Дотоод үйл ажиллагаандаа мэдлэг мэдээллийг түгээх, “Ногоон оффис”-ын аян болон “Цэцэгжүүлэх аян” зохион байгуулах зэрэг алхмуудыг амжилттай хэрэгжүүлэв. Мөн “Тэрбум Мод” сангийн хүрээнд 2022 оноос хойш нийт 10,000 гаруй модыг тарьсан байна.

Нийгмийн чиглэлд бид хүртээмжтэй оролцоог дэмжиж, ажилтнуудынхаа сэтгэл хангалуун байдлыг чухалчилдаг. 2025 оны эцэст нийт 257 ажилтантай болж, тэдний 63.4% нь эмэгтэйчүүд байна. Эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлсэн бизнесүүд болон ЖДҮ-ийг дэмжих зорилгоор EQ, AMP (TJ), GGSF зэрэг олон улсын байгууллагуудаас нийт 53 тэрбум төгрөгөөс давсан санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Энэхүү амжилт нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг дэмжих, тэгш боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн бидний тууштай зорилго, үнэт зүйлийн бодит илэрхийлэл юм.



Засаглалын түвшинд бид хариуцлагатай банкны үйл ажиллагааны үндэс болсон ёс зүйн дээд стандартыг мөрдөж, ил тод байдал, хариуцлага, эрсдэлийн зөв удирдлагыг хангаж ажилладаг. 2025 онд Авлигын эсрэг бодлогыг батлаж, ТУЗ-ийн түвшинд тогтвортой байдлыг хариуцах гишүүнийг тусгайлан томилов. Moody's зэрэглэл B2/Тогтвортой-гоос B1/Тогтвортой болж дэвшсэн нь бидний засаглалын хүчин чармайлтын баталгаа юм.

2025 оны бүтэн жилийн байдлаар Богд Банк нь БОНЗ-ын зарчмуудыг бүх үйл ажиллагаандаа улам гүнзгий нэгтгэсээр, тогтвортой, хариуцлагатай, хөгжин дэвжсэн ирээдүйг хамтдаа бүтээхэд тууштай ажиллаж байна.

Хүндэтгэсэн,

Г.Саруул
Гүйцэтгэх захирал



Тогтвортой хөгжлийн тайлангийн тухай

Энэхүү тайлан нь Богд Банк ХК-ийн 2025 оны 1 дүгээр сарын 1-нээс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд хэрэгжүүлсэн байгаль орчин, нийгэм, засаглал (БОНЗ)-ын чиглэл дэх үйл ажиллагаа, гүйцэтгэлийг нэгтгэн тусгасан болно.

Тайланг боловсруулахдаа олон улсын GRI Standards (2021) болон санхүүгийн байгууллагад зориулсан GRI Financial Services Sector Standard-ын шаардлагыг баримталсан бөгөөд холбогдох үзүүлэлтүүдийг эдгээр стандартын дагуу тодорхойлж, тайлагнасан болно.

Хүлэмжийн хийн ялгарлын тооцооллыг GHG Protocol-ын аргачлалд нийцүүлэн гүйцэтгэсэн бөгөөд тухайн тооцоололд ашигласан зарим тоон мэдээлэл нь боломжит өгөгдөлд тулгуурласан ойролцоо үнэлгээ болохыг үүгээр мэдэгдэж байна. Мөн тайланд тусгагдсан БОНЗ-ын мэдээлэл нь гуравдагч этгээдийн хараат бус аудит, баталгаажуулалтад хамрагдаагүй болно.

Тайланд агуулагдах санхүүгийн мэдээлэл нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Монголбанкны зохицуулалтын шаардлагад бүрэн нийцсэн болно.





БОГД БАНК

Удиртгал

Бидний тухай

Тогтвортой хөгжил

Байгаль орчин

Нийгэм

Засаглал

Бидний тухай


(GRI 2-1 – 2-6)



Богд Банк Тогтвортой хөгжлийн тайлан 2025 он

1.1 Байгууллагын ерөнхий мэдээлэл

Богд Банк нь Монгол Улсын банк, санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хувийн арилжааны банк бөгөөд харилцагч төвтэй үйлчилгээ, дэвшилтэт дижитал шийдэл, инновацад суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээгээрээ зах зээлд өрсөлдөх чадвараа бэхжүүлэн ажиллаж байна



1.2 Алсын Хараа, Эрхэм Зорилго, Үнэт Зүйлс

АЛСЫН ХАРАА

Дэлхийн шилдэг стандарт, туршлага, шинэ үеийн хандлага болон технологийн дэвшлийг ашиглан банк, санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, үнэ цэнийг төдийгүй ирээдүйдээ, өөртөө, банкандаа итгэх итгэлийг түгээгч банк байна.

ЭРХЭМ ЗОРИЛГО

Харилцагчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчдынхаа сэтгэл ханамжийг тэнцвэртэй, тогтвортой хангаж, үйлчилгээний чанар, хүртээмж, үр ашгийн үзүүлэлтээрээ олон улсын жишигт хүрсэн, харилцааг эрхэмлэсэн, технологид суурилсан банк байна.

ҮНЭТ ЗҮЙЛС

Банкны ажилтан бүр эрхэлсэн ажил үүргээ гүйцэтгэхдээ ИТГЭЛ/TRUST гэсэн монгол үгээр товчлогдсон илэрхийлэгдэх эрхэмлэн дээдлэх үнэт зүйлсийг цаг ямагт мөрдөж ажиллана.

1.3 Оролцогч талуудын тухай (GRI 2-1 – 2-6)

Богд Банк нь үйл ажиллагаандаа нөлөөлж буй болон өөрийн үйл ажиллагаанд нөлөөлөх боломжтой дараах үндсэн оролцогч талуудтай тогтмол харилцан ажилладаг. Үүнд харилцагчид, ажилтнууд, хөрөнгө оруулагчид болон олон улсын санхүүгийн байгууллагууд, зохицуулах байгууллагууд, салбарын холбоод, мөн олон нийт болон орон нутгийн иргэд багтана.

Банк нь оролцогч талуудтай харилцахдаа тэдгээрийн хэрэгцээ, хүлээлтийг тодорхойлох, үйл ажиллагаандаа тусгах зорилгоор дараах сувгуудыг ашигладаг.

- Харилцагчидтай салбар нэгж, дижитал сувгууд, хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, дуудлагын төвөөр дамжуулан харилцдаг
- Ажилтнуудтай дотоод уулзалт, сургалт, сэтгэл ханамжийн судалгаа, дотоод мэдээллийн сувгаар харилцдаг
- Хөрөнгө оруулагчид болон олон улсын байгууллагуудтай тогтмол тайлагнал, уулзалт, хяналт, үнэлгээний хүрээнд хамтран ажилладаг
- Зохицуулах байгууллагуудтай хууль, дүрмийн дагуу албан тайлагнал, хяналт шалгалтын хүрээнд харилцдаг
- Олон нийт болон орон нутгийн иргэдтэй нийгмийн хариуцлагын хөтөлбөр, санхүүгийн боловсролын арга хэмжээ, мэдээлэл түгээх үйл ажиллагаагаар дамжуулан харилцдаг



Оролцогч талуудын зүгээс банканд тавигдах гол хүлээлт нь найдвартай, ил тод үйл ажиллагаа, хариуцлагатай санхүүжилт, ажилтнуудын тогтвортой хөгжил, мөн нийгэмд эерэг нөлөө үзүүлэхэд чиглэгддэг.

Тогтвортой хөгжлийн стратегии (GRI 2-22 - 2-23)



2.1 Бидний оролцоо

Богд Банк нь байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа, нийгмийн хариуцлага, ил тод байдлыг тэргүүлэх чиглэлээр баримталдаг.

Энэхүү чиглэлийн хүрээнд бид Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоонд нэгдэж, 2015 онд албан ёсны гишүүн болсон. Үүнээс хойш Богд Банк нь Тогтвортой хөгжлийн зорилгуудыг өдөр тутмын үйл ажиллагаа болон банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй нягт уялдуулан хэрэгжүүлсээр ирсэн билээ.

Банкны "Байгаль орчин, нийгмий хариуцлага, жендерийн эрх тэгш байдлын бодлого" -ын хүрээнд зээл олголтын үйл ажиллагаандаа тогтвортой санхүүгийн зарчмуудыг мөрдлөг болгож, байгаль орчин болон нийгмийн хариуцлагыг дэмжин ажиллаж байна. Мөн БОНЗ-ын бодлогын хүрээнд банк нь эрчим хүчний хэмнэлттэй шийдлүүдийг хэрэгжүүлэх, ус болон цаасны хэрэглээг бууруулах, хог хаягдлыг дахин боловсруулах, бүх хэрэглэгчдэд хүртээмжтэй, тэгш оролцоог хангах үйлчилгээг үзүүлэхэд анхаарч ажиллаж байна.



2.1 Бидний оролцоо

Богд Банк нь ТоС Холбооны 8 зарчмыг үйл ажиллагаандаа амжилттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Жил бүр бид ТоС-ийн хэрэгжилтийн тайланг боловсруулан ТоС Холбоо-д хүргүүлдэг бөгөөд энэхүү тайланг Монголбанк болон Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) хамтран үнэлж, дүгнэлт гаргадаг.


Мөн Богд Банк нь ТоС-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зориулан тусгай ажлын хэсэг байгуулсан бөгөөд ажлын хэсэгт банкны газар, нэгж бүрийн төлөөллүүд байдаг. Ингэснээр зөвхөн банкны ТоС алба гэлтгүй бусад газар, нэгжүүд ч мөн адил тогтвортой байдалтай холбоотой мэдээ мэдээллийг цаг алдалгүй авж бусад ажилтнуудад түгээх боломжийг бий болгодог билээ.



2.2 Тэргүүлэх БОНЗ-ын сэдвүүд (GRI 3 - Materiality)

2025 онд Богд Банкны тэргүүлэх материаллаг сэдвүүдийг дараах байдлаар тодорхойлсон:

Сэдэв	Холбогдох GRI	Тэргүүлэх байдал
Хүлэмжийн хийн ялгарал (Scope 1, 2)	GRI 305	Өндөр
Ногоон санхүүжилт ба зээл	GRI FS8	Өндөр
Жендерийн тэгш байдал	GRI FS8	Дунд
ЖДҮ-ийн санхүүжилт	GRI FS7	Өндөр
Ажилтны хөгжил ба сайн сайхан	GRI 401, 404	Дунд
Санхүүгийн хүртээмж	GRI FS13	Өндөр
Засаглал ба ил тод байдал	GRI 2-9 to 2-21	Өндөр
Нөөцийн хэмнэлт	GRI 301, 303	Дунд
Авлигын эсрэг	GRI 205	Өндөр
Мэдээллийн аюулгүй байдал	GRI 418	Өндөр



Байгаль орчин (GRI 300 Series)




3. Байгаль орчин



Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээнд хэрэгжүүлж буй санаачилгынхаа хүрээнд бид Байгаль орчинд ээлтэй хэрэглээг дэмжих, Ногоон хэрэглээний зээл, Эко автомашины зээл зэрэг бүтээгдэхүүнээр дамжуулан хувь хүмүүсийн тогтвортой сонголтыг дэмжиж байна. Энэхүү зээлүүдээр дамжуулан бид байгаль орчны нөлөөллийг бууруулж, экологид ээлтэй хэрэглээг нэмэгдүүлэн, илүү ногоон ирээдүйг цогцлоохыг зорьж байлаа билээ.

Богд банк нь ногоон санхүүжилт, нөөцийн үр ашигтай хэрэглээ, байгальд ээлтэй үйл ажиллагааг тэргүүн зорилтоо болгон ажилласаар ирсэн билээ. Бид тогтвортой бизнесийг дэмжиж, хог хаягдлыг бууруулахын зэрэгцээ эрчим хүчний хэмнэлт болон дижитал шилжилтийг идэвхтэй дэмжин ажиллаж байна.



3.1 Хүлэмжийн хийн ялгарал (GRI 305)

Богд Банк нь 2025 оноос эхлэн GHG Protocol стандартын дагуу 1-р болон 2-р хүрээний хүлэмжийн хийн ялгарлыг тооцох аргачлалыг боловсруулан дотооддоо батлан 2025 оны банкны хүлэмжийн хийн ялгарлыг тооцож эхэлсэн.

2025 оны байдлаар нийт **377.72 тонн** хүлэмжийн хийг ялгаруулаад байна.

Хүрээ 1 (Scope 1):

1-р хүрээ буюу Богд банкны хэмжээнд үйл ажиллагаагаараа шууд ялгаруулж буй хүлэмжийн хий 2025 оны байдлаар 7.3 тонн байна.

Хүрээ 2 (Scope 2):


2-р хүрээ буюу Богд банкны бүх салбар нэгж, оффис, хаяг, цахилгаан машинуудыг цэнэглэх зэрэг цахилгааны хэрэглээнээс үүсэх ялгарлын хэмжээ 370.4 тонн байна.

Зарим тооцоолол хийхэд шаардлагатай өгөгдөл бүрэн бүрдээгүй байгаа тул энэхүү тооцооллын үр дүн нь ойролцоо үнэлгээ бөгөөд бодит ялгарлын хэмжээг бүрэн илэрхийлээгүй байж болзошгүй. Цаашид үнэлгээний өгөгдлийн нарийвчлалыг сайжруулахаар зорьж байна.

3.2 Ногоон санаачилгууд

"Тэрбум мод" сан




"Тэрбум мод" сангийн хүрээнд бид жил бүр мод тарьдаг бөгөөд 2025 оны 5-р сарын 8-ны өдөр Гачууртын эко цэцэрлэгт хүрээлэнд Арилжааны банкууд хамтран Тэрбум мод сангийн зохион байгуулалтан дор мод тарив.



2022 оноос хойш нийт ойролцоогоор **12,500** шилмүүст болон навчит мод тарьсан байна.

Дэлхийн байгаль орчны өдрүүд

Сар бүр дэлхийн байгаль орчны өдрүүдэд тохиолдуулан мэдээлэл бэлтгэн олон нийтэд түгээж эхэлсэн.



3.2 Ногоон санаачилгууд

"GREEN OFFICE" аянг зохион байгуулав

Богд Банк дотооддоо анх удаа **"Green Office"** аяныг **2025 оны 6-р сарын 16-наас 7-р сарын 7-ны** хооронд амжилттай зохион байгууллаа.



"Санаачилга бүр өөрчлөлт авчирна" уриан дор зохион байгуулагдсан уг аяны үндсэн зорилго нь тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилт гэж юу болох талаар суурь мэдлэг олгох, энэ сэдвийн ач холбогдлыг ажилтнуудад ойлгуулах, тэдний оролцоог нэмэгдүүлэхэд оршсон юм.



3.2 Ногоон санаачилгууд

"GREEN OFFICE" аянт зохион байгуулав

Аян долоо хоног бүр өөр өөр сэдвийг хамарч, мэдээ мэдээлэл түгээх, ажилтнуудыг идэвхжүүлэх сорилт (challenge) зарлах зэрэг олон төрлийн сонирхолтой, хүртээмжтэй арга хэмжээнүүдийг багтаасан. Энэхүү санаачилга нь тогтвортой байдлыг байгууллагын соёлын нэг хэсэг болгон төлөвшүүлэх чухал алхам боллоо.



Аяны хүрээнд хүрсэн гол үр дүн:

- Тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийн талаарх ойлголт нэмэгдсэн
- Ажилтнууд өөрсдийн хүлэмжийн хий ялгаруулалтыг тооцож сурах боломжтой болсон
- Хуванцар хэрэглээний талаарх мэдээлэл, бууруулах зөвлөмжүүд хүргэгдсэн
- Цаасны хэрэглээтэй холбоотой мэдээлэл, хэмнэх зөвлөмжүүд хүргэгдсэн
- “Ногоон санаа” сэдвийн хүрээнд ажилтнуудын оролцоог урамшуулсан
- Хуванцар хэрэглээг бууруулах зорилгоор ажил дээрээ хувийн аяга авчрах уриалга гаргасан
- Аянгийн үеэр хийгдсэн санал асуулгын үр дүнд ажилтнуудын дунд шинэ клуб үүсэх боломж гарж ирсэн.



3.2 Ногоон санаачилгууд

"ЦЭЦЭГЖҮҮЛЭХ" аянг зохион байгуулав

"Цэцэгжүүлэх" аяныг байгууллагын хэмжээнд хоёр долоо хоногийн хугацаанд амжилттай хэрэгжүүлэв. Уг аянд ажилтнууд идэвхтэй оролцож, хамтран ажиллагсдадаа ширээний ургамал бэлэглэх замаар ажлын орчныг сайжруулах, эерэг уур амьсгалыг дэмжихэд бодит хувь нэмэр орууллаа.



Аяны үр дүнд газар, хэлтэс бүрийн ажилтнууд өөрийн ширээний ургамалтай болж, байгууллагын дотоод уур амьсгал, хамтын харилцаа илт сайжирсан. Мөн оффисын орчинд ногоон байгууламж нэмэгдсэнээр агаарын чанар сайжрах, ажилтнуудын төвлөрөл болон сэтгэл ханамж нэмэгдэх зэрэг эерэг үр нөлөө бий болов.



Энэхүү санаачилга нь ажилтнуудын оролцоог дэмжих, эрүүл, таатай ажлын орчин бүрдүүлэх, байгаль орчинд ээлтэй хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн тогтвортой хөгжлийн зорилтуудтай нийцсэн үйл ажиллагаа боллоо.

3.3 НӨӨЦИЙН ХЭМНЭЛТ (GRI 301, 303)

Богд Банк нь өдөр тутмын үйл ажиллагаандаа байгаль орчинд үзүүлэх нөлөөг бууруулах, байгууллагын нөөцийн хэрэглээг оновчтой зохион байгуулах зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Бичиг хэргийн хэрэглээний хяналт:

- Салбаруудын бичгийн цаасны сарын хэрэглээг тогтмол хянаж, харьцуулсан дүн шинжилгээ хийж эхэлсэн нь нөөцийн төлөвлөлтийг сайжруулахад тус болж байна.
- Бичгийн цаасны хэрэглээ болон принтерийн хорны зарцуулалтад хяналт тавих үүнээс зээлийн гаралт болон бусад мэдээллийг график хэлбэрээр харуулж, үр ашигтай байдалд дүн шинжилгээ хийж байна.
- Принтер, компьютерийн худалдан авалтыг 2025 онд 80% бууруулав.
- Салбар болон төв дээрх эрэлт, илүүдлийн нөөцийг тодорхойлон хооронд нь шилжүүлэн ашиглах аргыг тогтмол хэрэгжүүлэв.



Тогтвортой хэрэглээний дадлыг төлөвшүүлэх нь

Уулзалт болон сургалтын үед нэг удаагийн аяга, хэрэгслийн хэрэглээг зогсоож, дахин ашиглагдах шаазан аяга, таваг тогтмол хэрэглэж эхэлсэн. Энэ нь хог хаягдлын хэмжээг бууруулах, тогтвортой хэрэглээг дэмжих чухал алхам болж байна.

Худалдан авалтын давхардлыг бууруулах зохицуулалт:

Сарын төсвийн худалдан авалтыг хэлэлцэхээс өмнө үлдэгдэл болон байгаа нөөцийг тогтоох журам нэвтрүүлснээр давхардсан худалдан авалтыг багасгаж, үр ашиггүй зардлыг бууруулсан.



БОГД БАНК

Удиртгал

Бидний тухай

Тогтвортой хөгжил

Байгаль орчин

Нийгэм

Засаглал

Нийгэм

(GRI 400 Series)



Богд Банк Тогтвортой хөгжлийн тайлан 2025 он

4. Нийгэм



Богд Банк нь жижиг, дунд бизнесийн санхүүжилт, эмэгтэйчүүдийн эдийн засгийн оролцоог нэмэгдүүлэх, ногоон зээл, хөдөө орон нутгийн хөгжил, мөн дижитал шилжилтийг дэмжих замаар БОНЗ-ын санаачилгуудын хэрэгжүүлж нийгмийн нөлөөг бий болгохыг зорин ажиллаж байна.

4.1 Хүний нөөц (GRI 401, 405)

Нийт ажилтны тоо

257

36.6%

Эрэгтэй


63.4%

Эмэгтэй

Удирдлагын баг


9

Эрэгтэй

7

Эмэгтэй

2

Эрэгтэй
36.6%

Эмэгтэй
63.4%

Дундаж үзүүлэлтүүд

Дундаж нас

34 нас

Сургалтын хугацаа


7 өдөр

4.2 Ажилтны хөгжил, сайн сайхан байдал (GRI 404)

Тайлант хугацаанд банк нь ажилтнуудын мэдлэг, ур чадварыг хөгжүүлэх, эрүүл, аюулгүй, тав тухтай ажлын орчныг бүрдүүлэхэд чиглэсэн олон талт арга хэмжээг хэрэгжүүллээ.

4.2 АЖИЛТНЫ ХӨГЖИЛ, САЙН САЙХАН БАЙДАЛ (GRI 404)

Ажилтнуудын тасралтгүй хөгжлийг дэмжих зорилгоор зайнаас суралцах боломжийг нэмэгдүүлж, дотоод сургалтын цахим платформыг нэвтрүүлсэн. Мөн гадаад болон дотоод сургалтын чанарыг сайжруулж, сургалтын агуулга, хөтөлбөрийг баяжуулснаар ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн.



Ажилтнуудын сайн сайхан байдлыг хангах хүрээнд нийт ажилтнуудын үндсэн цалинг нэмэгдүүлж, хөдөлмөрийн үнэлэмжийг дэмжсэн. Түүнчлэн ажилтнуудын эрүүл мэндийг дэмжих зорилгоор идэвхтэй хөдөлгөөнийг уриалсан санаачилгыг хэрэгжүүлж, цахилгаан шат ашиглахын оронд шат ашиглах соёлыг төлөвшүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулж байна.

Ажлын орчныг сайжруулах чиглэлээр арын оффисын ажлын байрыг бүрэн шинэчлэн засварлаж, илүү тав тухтай, эрүүл орчныг бүрдүүлсэн. Үүнд агаарын солилцоог сааруулдаг тусгаарласан өрөөнүүдийг багасгаж, задгай төлөвлөлт бүхий орчныг бий болгосон. Мөн барилгын материалын сонголтод анхаарч, химийн үнэр ялгаруулалт багатай, байгальд ээлтэй, сэргээгдэх боломжтой хулсан орц бүхий хавтан, дуу чимээ шингээлт сайтай, үнэр ялгаруулдаггүй эко шийдлүүдийг (япон технологийн шалны материал зэрэг) ашиглалаа.



4.3 Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдал (GRI 403)



Галын аюулгүй байдал, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангах чиглэлээр холбогдох үйл ажиллагааг тогтмол, тасралтгүй хэрэгжүүлэн ажилладаг. Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/135 дугаар тушаалын дагуу боловсруулсан “Гал түймэр унтраах шуурхай төлөвлөгөө”-г мөрдөн ажиллаж байна.


Мөн салбарын ажилтнуудад галын аюулаас урьдчилан сэргийлэх, галын хор ашиглах дадлагын сургалтыг тогтмол зохион байгуулдаг. Үүний зэрэгцээ хөдөлмөрийн дотоод журмыг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуультай нийцүүлэн байнга мөрдөж, ажилтнуудын аюулгүй байдал, эрх ашгийг ханган ажиллаж байна.

4.4 Санхүүгийн боловсрол ба санхүүгийн хүртээмж (GRI FS13, FS14)

Санхүүгийн боловсрол

“LEVEL UP хөтөлбөр

Ахлах ангийн сурагчдад зориулсан санхүүгийн боловсрол олгох “Level Up” арга хэмжээнд оролцож, хүүхдүүдийн мөнгөний мэдлэгийг дэмжсэн.



Санхүүгийн боловсролын видео контент

Залуучуудад зориулан санхүүгийн боловсрол өгөх зорилгоор шинээр видео контент хийж эхэлсэн байгаа ба 10/1-ийн дүрмээр хадгалаж эхлэх, өөрийн санхүүг зохицуулж сурах гэх зэрэг мэдээ мэдээллийг түгээж эхэлсэн.



Дэлхийн мөнгөний 7 хоног аян

“Санхүүгийн зөв шийдвэр – Маргаашийн амжилтын эхлэл” уриан дор Монгол Улсад 13 дахь жилдээ зохион байгуулагдсан Дэлхийн мөнгөний 7 хоног аянд оролцож, сошиал орчин дахь санхүүгийн залилангаас сэргийлэх, эрсдэлтэй үед сэтгэл хөдлөлөө зөв удирдах талаар мэдээлэл хүргэлээ.

4.4 Санхүүгийн боловсрол ба санхүүгийн ХҮРТЭЭМЖ (GRI FS13, FS14)

Санхүүгийн хүртээмж ба урамшуулалт аянууд

“Дурсамж түгээ” хадгаламжийн урамшуулалт аян

Хүүхдийн мөнгийг хуримтлал болгохыг уриалсан энэхүү аян нь гэр бүлийн санхүүгийн төлөвлөлтийг дэмжих зорилготой байсан бөгөөд аяны хүрээнд хадгаламж нээсэн харилцагчдад аяллын эрх бүхий урамшуулал олгосон. Уг урамшуулал нь санхүүгийн боловсролыг нэмэгдүүлж, хуримтлалын ач холбогдлыг олон нийтэд таниулахад чухал хувь нэмэр оруулсан юм.



“Итгэл” хадгаламжийн гарын бэлэгтэй урамшуулалт аян

Хуримтлалын дадлыг дэмжих зорилготой “Итгэл” аянаар дамжуулан шинэ хадгаламж нээсэн харилцагчдад бэлгийн урамшуулал олгож, санхүүгийн тогтвортой ирээдүйн төлөө хийх эхний алхмыг бий болгосон билээ. Энэхүү аян нь иргэдийг хуримтлал үүсгэх, өөрийн ирээдүйд итгэлтэй хандахад чиглэсэн бодит дэмжлэг болсон хэмээн үзэж байна.



18%-ийн хүүтэй хадгаламжийн бүтээгдэхүүн

Тайлант хугацаанд хадгаламж эзэмшигчдийг идэвхжүүлэх урамшуулалт аяныг зохион байгуулж, харилцагчдын хуримтлалыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. Мөн өндөр хүүтэй хадгаламжийн бүтээгдэхүүн нэвтрүүлснээр тогтмол хуримтлал үүсгэх боломжийг бүрдүүлсэн.



4.4 Санхүүгийн боловсрол ба санхүүгийн ХҮРТЭЭМЖ (GRI FS13, FS14)

Санхүүгийн хүртээмж ба урамшуулалт аянгууд



“Бэлэг дүүрэн сар” урамшуулалт аян

Тайлант хугацаанд нийт хадгаламж эзэмшигч харилцагчдад зориулан шинэ жилийн баярыг угтан “Бэлэг дүүрэн сар” урамшуулалт аяныг амжилттай хэрэгжүүлэв. Энэхүү аян нь харилцагч хадгаламждаа орлого нэмэх бүрт болон анх удаа хадгаламж нээлгэж байгаа харилцагч бүрт шинэ жилийн бэлэг олгож, хадгаламжийн идэвх, өсөлтийг дэмжих зорилготой байв.

“Найзаа урих” урамшуулалт аян

Харилцагчдын оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор “Найзаа урих” урамшуулалт аяныг нэг сарын хугацаанд зохион байгуулж, найзаа амжилттай урьсан болон уригдсан харилцагч бүрт урамшуулал олгов.



Банк нь олон улсын ISO13616 стандартад нийцсэн IBAN дансны системд шилжсэнээр харилцагчдын гадаад, дотоод төлбөр тооцоог илүү найдвартай, шуурхай болгох нөхцөлийг бүрдүүлсэн.

Төлбөрийн картын үйлчилгээ



Төлбөрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэв. Үүнд:

- АТМ ашиглалтын шимтгэлийг бууруулах хамтын ажиллагаанд нэгдэж, харилцагчдын зардлыг бууруулсан.
- Карт захиалах болон картын удирдлагын үйлчилгээг цахимжуулж, зайнаас үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн.
- Харилцагчдын хэрэглээг дэмжих зорилгоор cashback болон урамшуулалт аяныг хэрэгжүүлсэн.


4.4 Санхүүгийн боловсрол ба санхүүгийн ХҮРТЭЭМЖ (GRI FS13, FS14)

Санхүүгийн хүртээмж ба урамшуулалт аянгууд

Жижиг, дунд бизнесийг дэмжих (ЖДБ)

Банк нь Монгол Улсын эдийн засгийн чухал тулгуур болсон жижиг, дунд бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор “ЖДБ дэмжих аян”-ыг хэрэгжүүллээ. Уг аяны хүрээнд санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэхээс гадна эмэгтэй бизнес эрхлэгчид болон байгаль орчинд ээлтэй, эрчим хүчний хэмнэлттэй төслүүдийг онцгойлон дэмжив.

Мөн зээлийн бүтээгдэхүүний нөхцөлийг сайжруулж, эргэлтийн хөрөнгийн зээлийн хугацааг уртасгах, давтан зээлдэгчдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх, барьцаат зээлийн шийдвэрлэх хугацааг богиносгох зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнээс гадна харилцагчдад санхүүгийн зөвлөгөө, бизнесийн хөгжлийг дэмжих хамтын ажиллагааны боломжийг олгосон нь ЖДБ-ийн тогтвортой өсөлтийг дэмжихэд чиглэлээ.



Даатгалын зуучлалын үйлчилгээ

Банк нь харилцагчдын санхүүгийн эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх зорилгоор даатгалын зуучлалын үйлчилгээг үзүүлж, хөрөнгө, амь нас, эрүүл мэнд, бизнесийн эрсдэлийг хамарсан бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Тайлант хугацаанд холбогдох зохицуулалтын шаардлагын хүрээнд ипотекийн зээлдэгчдэд зориулсан урт хугацааны амь насны даатгалын бүтээгдэхүүнийг хамтрагч даатгалын байгууллагуудтай хамтран нэвтрүүлж, харилцагчдын санхүүгийн хамгаалалтыг сайжруулахад анхааран ажиллалаа.

4.5 Тогтвортой санхүүжилт (GRI FS13, FS14)

Манай банкнаас санал болгож буй тогтвортой санхүүгийн бүтээгдэхүүнүүд:



**ЭКО
АВТОМАШИНЫ
ЗЭЭЛ**



**НОГООН
ХЭРЭГЛЭЭНИЙ
ЗЭЭЛ**



**БИЗНЕС ЭРХЛЭГЧ
ЭМЭШТЭЙЧҮҮДИЙГ
ДЭМЖИХ ЗЭЭЛ**



**ДУЛААЛГЫН
ЗЭЭЛ**

Тогтвортой санхүүжилт

2025 онд банк нь жижиг, дунд бизнес эрхлэгчид, ногоон салбар болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр дунд хугацааны санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүллээ. Үүнд:

Enabling Capital хөрөнгө оруулалтын сангаас санхүүжилт татав:

- 2025 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр зургаа дахь, 12 дугаар сарын 17-ны өдөр долоо дахь зээлийн гэрээг байгуулж, нийт **8 сая ам.долларын** дунд хугацааны санхүүжилт амжилттай татан төвлөрүүлсэн. Энэхүү санхүүжилт нь ЖДБ болон ногоон салбарт чиглэсэн.

AMP (TJ) хөрөнгө оруулалтын сангаас анхны санхүүжилт татав:

- 2025 оны 9 дүгээр сарын 25-ны өдөр анхны зээлийн гэрээг байгуулж, нийт **5 сая ам.долларын** дунд хугацааны санхүүжилт татан төвлөрүүлсэн. Уг санхүүжилт нь жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд чиглэсэн.

GGSF (TJ) хөрөнгө оруулалтын сангаас нэмэлт санхүүжилт татав:

- 2025 оны 12 дугаар сарын 2-ны өдөр хоёр дахь **5 сая ам.долларын** зээлийн гэрээг байгуулж, эхний олголтоор 2 сая ам.долларын дунд хугацааны санхүүжилт татан төвлөрүүллээ. Энэхүү санхүүжилт нь эмэгтэй бизнес эрхлэгчдэд чиглэсэн юм.



4.6 Олон нийтэд мэдээлэл түгээх

Ажилтнуудын оролцоо ба дотоод соёл

“Тогтвортой байдлын” сонин

Байгууллагын дотоод соёлыг бэхжүүлэх зорилгоор сар бүрийн “Тогтвортой байдлын сонин”-г ажилтнуудад тогтмол хүргэж эхэлсэн.



Энэхүү сонин нь тогтвортой хөгжлийн талаарх үндсэн ойлголт, ач холбогдлыг ажилтнуудад ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэхээс гадна өдөр тутмын амьдрал, хэрэглээнд хэрэгжүүлэх боломжтой зөвлөмж, шийдлүүдийг багтааснаараа онцлог юм. Мөн тогтвортой хөгжилтэй холбоотой шинэ нэр томъёо, чиг хандлагыг танилцуулж, ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэхэд чиглэсэн мэдээллийг системтэйгээр хүргэж байна.

Үүнээс гадна байгууллагын дотоод соёлыг дэмжих зорилгоор ажилтнуудын хэрэгжүүлж буй “ногоон” дадал, туршлагыг хуваалцах “Богдын булан” хэсгийг тусгасан бөгөөд энэ нь хамт олны оролцоог нэмэгдүүлэх, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх, тогтвортой хэрэглээг дэмжих эерэг нөлөө үзүүлж байна.

4.6 Олон нийтэд мэдээлэл түгээх

Ажилтнуудын оролцоо ба дотоод соёл

Ажилтнуудын имэйл гарын үсэгт тогтвортой хөгжлийн уриалга оруулсан нь

Тогтвортой хөгжлийн зорилтуудын хүрээнд байгууллагын дотоод соёл, харилцааны хэлбэрийг байгаль орчинд ээлтэй, хариуцлагатай чиглэлд уялдуулах зорилгоор ажилтнуудын и-мэйлийн гарын үсэг (Signature) хэсэгт тогтвортой хөгжилд уриалсан товч сануулгыг нэмсэн. Энэ нь байгууллагын нийт ажилтнуудын өдөр тутмын харилцаанд ТоС-ийн үнэт зүйлсийг тусгах чухал алхам болж байна.

Нийгмийн хариуцлага

Банк нь Америкийн Худалдааны Танхим (AmCham)-ын гишүүн байгууллагын хувьд тайлант хугацаанд тус байгууллагын Нийгмийн хариуцлагын (CSR) хороонд гишүүнээр элсэн орсон. Ингэснээр нийгмийн хариуцлага, тогтвортой хөгжлийн чиглэлээр туршлага солилцох, хамтын санаачилгад оролцох, шилдэг туршлагыг нэвтрүүлэх боломжийг өргөжүүллээ.



Олон нийтэд мэдээлэл түгээх



Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан сонин

Эмэгтэй бизнес эрхлэгчдэд зориулсан бизнесийн мэдээллийн товхимол №1-ийг боловсруулан гаргаж, бизнесийн орчин, санхүүжилтийн боломж, зах зээлийн чиг хандлагын талаарх мэдээллийг нэгтгэн хүргэсэн. Энэхүү товхимол нь эмэгтэй бизнес эрхлэгчдийн мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн болно.

Дэлхийн байгаль орчны өдрүүдийг тохиолдуулан байгаль орчны мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор холбогдох мэдээлэл, зөвлөмжийг тогтмол бэлтгэн дотоод болон гадаад сувгуудаар түгээж эхэлсэн

4.6 Олон нийтэд мэдээлэл түгээх

Олон нийтэд мэдээлэл түгээх

“Ногоон эрэл” сонин руу мэдээлэл хүргүүлэх

Байгууллагын байгаль орчин, нийгэм, засаглалыг (ESG) дэмжих үйл ажиллагааг олон нийтэд таниулах үүднээс **“Ногоон эрэл”** сонинд холбогдох мэдээллийг хүргүүлж, 6-р сарын дугаарт нийтлүүлэв.



Засаглал

(GRI 2-9 – 2-21, GRI 205)

5. Засаглал



Богд банк ил тод байдал, ёс зүйтэй банкны үйл ажиллагаа болон хариуцлагатай засаглалыг эрхэмлэдэг.

Бид санхүүгийн ил тод байдлыг нэмэгдүүлж, БОНЗ-ын зарчмуудыг үйл ажиллагаандаа нэгтгэн, ЖДҮ-үүдийг дэмжин ажиллаж байна. Цахим шилжилт болон тогтвортой санхүүгийн шийдлээр дамжуулан бид инновац, хүртээмжтэй хөгжил болон урт хугацааны эдийн засгийн өсөлтийг дэмждэг.

5.1 Төлөөлөн удирдах зөвлөл (GRI 2-9)



Л.Болдхуяг

ТУЗ-ийн дарга, МУ-ын Гавъяат Эдийн Засагч

- Монголын санхүүгийн зах зээлд 25 гаруй жилийн туршлагатай, Боди корпорацийн хамтран үүсгэн байгуулагч
- Монгол Улсын томоохон арилжааны банкны ТУЗ-ийн гишүүн, даргаар ажиллаж байсан
- Шведийн Вант Улсын Хүндэт консул



Г.Саруул

Гүйцэтгэх захирла, ТУЗ-ийн гишүүн



Ж.Нарантуяа

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Жан Торстэн Дазер

ТУЗ-ийн гишүүн



Р. Баясгалан

ТУЗ-ийн гишүүн



Д.Моломжамц

ТУЗ-ийн гишүүн



Рожер Томас Мойес

ТУЗ-ийн хараат бус гишүүн



Б.Ойгонжаргал

ТУЗ-ийн гишүүн



Филипп Кахэн

ТУЗ-ийн хараат бус гишүүн

2025 оны хагас жилийн хугацаанд ТУЗ-ийн түвшинд тогтвортой байдлын асуудлыг хариуцан ажиллах гишүүнийг тодорхойлж, холбогдох үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх зохицуулалтыг бүрдүүлэв.

5.2 Удирдлагын баг


Г.Саруул
Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүн

- Санхүүгийн салбарт 20 гаруй жилийн туршлагатай
- Монголын Хөрөнгийн Биржийн дэд гүйцэтгэх захирлаар ажиллаж байсан
- APM Futures болон Rosenthal Collins Group компанид Ази, Орос, ТУХН-ийн бүсийг хариуцсан захирлаар ажилласан
- Mobium Mortgage Group компанид ахлах банкирээр ажиллаж байсан


М.Алтанбагана
Бизнес банк хариуцсан захирал

М.Бат-Өлзий
Санхүү хариуцсан захирал

Б.Билэгт
Байгууллагын банк хариуцсан захирал

М.Алтанзүрх
Мэдээллийн технологи хариуцсан захирал

Ч.Банчин
Бизнес хөгжил хариуцсан захирал

О.Өнөрцэцэг
Үйл ажиллагаа хариуцсан захирал

Л.Хонгорзул
Эрсдлийн удирдлага хариуцсан захирал

Э.Ган-Эрдэнэ
Хөрөнгө зохицуулалт хариуцсан захирал

5.3 Богд банкны Тогтвортой байдлын бодлого ба хэрэгжилт

Богд банкны Байгаль орчин, Нийгмийн хариуцлага, Жендерийн тэгш байдлын бодлого нь 2022 онд батлагдаж, холбогдох үүрэг, зарчмуудыг тодорхойлсон. Энэхүү бодлогоор дамжуулан тогтвортой төсөл, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг дэмжиж, эдийн засгийн төрөлжилт, тогтвортой санхүүжилтэд хувь нэмэр оруулж байна.

Мөн байгаль орчин, нийгэм, жендерийн эрсдэлийг удирдах тогтолцоог бүрдүүлсэн ба энэ хүрээнд БОНЗ-ны эрсдэлийн үнэлгээ, удирдлагын журамыг батлан 2024 онд шинэчлэн баталсан.

Тогтвортой байдлын ажлын хэсэг

Банк нь ТоС-ын хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааг жил бүр зохион байгуулах ажлын хэсэгтэй бөгөөд энэ нь банкны газар, нэгж бүрийн төлөөллүүдийг оролцуулан, бодлого, үйл ажиллагааг уялдуулан хэрэгжүүлэх, хяналт, гүйцэтгэлийг системтэй хангах зохицуулалтыг бүрдүүлдэг. Энэ тогтмол зохион байгуулалт нь байгууллагын хэмжээнд тогтвортой байдлын үйл ажиллагааг тогтвортой, үр дүнтэй хэрэгжүүлэхэд чухал үүрэгтэй юм.

Гомдол хүлээн авах суваг

Банкны вебсайтны ТоС буланд гомдол хүлээн авах сувгийн мэдээллийг нэмсэн бөгөөд энэ нь авлига, хээл хахуулийн аливаа эрсдэл, зөрчилд холбогдох мэдээллийг шуурхай хүлээн авч хариу арга хэмжээ авах боломжийг бүрдүүлж байна.

grievance@bogdbank.com

Авлига, хээл хахуулийн эсрэг бодлого

Банк нь 2025 онд авлига, хээл хахуулийн эсрэг бодлого баталсан. Энэхүү бодлогын зорилго нь банкны бизнесийн болон ажилтны ёс зүйг эрхэмлэсэн, шударга ёс, ил тод байдал, банкны нэр хүндийг хамгаалахад чиглэсэн, авлига, хээл хахуулиас ангид байж, ил тод нээлттэй, хариуцлагатай байдлыг дээшлүүлэх, гуравдагч талуудтай аливаа бизнесийн харилцаа үүсгэхдээ хээл, хахуулийн эсрэг зарчмуудыг баримтлах, ажилтнуудын үйл хэрэг болон авах арга хэмжээг тодорхойлох, авлига, хээл хахуулийн зарчим, тогтолцоог бий болгоход оршино.


5.4 Ил тод байдал ба тайлагнал

БОНЗ-ын тайланг тогтмол хүргүүлж байна

Санхүүжилт татсан Олон Улсын санхүүгийн байгууллагуудад БОНЗ-той холбоотой шаардлага бүхий тайлан, маягт, мэдээллүүдийг цаг тухайд нь хүргүүлсэн.

Байгаль орчин, нийгэм, засаглалын хүрээ

Байгууллагын 2022 оноос 2024 он хүртэлх хийсэн ажлуудыг нэгтгэн боловсруулж БОНЗ-ын хүрээг анх удаа англи хэл дээр бэлтгэв.



2024 оны Тогтвортой байдлын тайлан

Байгууллагын тогтвортой хөгжлийн бодлого, үйл ажиллагааг олон улсын түвшинд танилцуулах зорилгоор 2024 оны тогтвортой хөгжлийн тайланг англи хэл дээр боловсрууллаа.



5.4 Ил тод байдал ба тайлагнал

Европын холбооны GGBI хөтөлбөрт зориулсан One Pager бэлтгэсэн

GGBI хөтөлбөрт оролцох зорилгоор богино хэмжээний танилцуулга (One Pager)-г бэлтгэж, байгууллагын ногоон, тогтвортой санхүүгийн чиглэлийг товч тодорхой байдлаар бэлтгэн хүргүүлсэн.

Зээлжих зэрэглэл ба санхүүгийн тогтвортой байдал


2025 онд **Moody's агентлаг** Монгол Улсын зээлжих зэрэглэлийг **“B1/Тогтвортой”** болгосны дараа Монголын 7 банкны зээлжих зэрэглэл сайжирсан бөгөөд үүнд Богд Банк багтав. Банкны зэрэглэл өнгөрсөн жил “B2/Тогтвортой” байсан бол 2025 онд “B1/Тогтвортой” болж ахисан байна. Энэ ахиц нь гаднаас хөрөнгө оруулалт татах боломж, гадаад санхүүжилтийн нөхцөл, банкны бүтээгдэхүүний хүртээмж, үр өгөөжийг сайжруулахад эерэг нөлөө үзүүлж байна.



5.5 Байгууллагын дотоод чадавхи

ТоС сургалтын гарын авлага боловсруулсан

Тогтвортой хөгжлийн үндсэн ойлголт, БОНЗ-ын агуулгыг багтаасан сургалтын гарын авлагыг боловсруулан ажилтнуудад хүргэж эхэлсэн.




Ажилтны мэдлэг, ойлголт нэмэгдүүлэх санаачилга

Банк нь ажилтнуудын мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх, тогтвортой хэрэглээ, ногоон дадлыг төлөвшүүлэх зорилгоор богино хэмжээний мэдэлэгийн постеруудыг бэлтгэн түгээж эхэлсэн. Энэхүү мэдээлэл нь ажилтнуудын өдөр тутмын үйл ажиллагаанд шууд хэрэгжүүлэх зөвлөмж, санаачилгыг агуулсан бөгөөд дотоод соёл, тогтвортой байдлын мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн.



5.6 Мэдээллийн аюулгүй байдал (GRI 418)

- Банкны мэдээллийн аюулгүй байдлын бодлогыг шинэчиллээ.
- Монгол Улсын кибер аюулгүй байдлын хуулийн 17.1.7 заалтыг үндэслэн мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэсэн.



- **PCI DSS (Payment Card Industry Data Security Standard)** стандартыг нэвтрүүлж хэрэгжүүлэх ажлыг эхлүүллээ.
- **PAM (Privileged Access Management)** болон Log server-ийг шинээр нэвтрүүлсэн.
- Харилцагчдын хувийн хэргийн цахимжилтыг нэмэгдүүлж, харилцагчийн хувийн хэргийг **89.7%**, зээлийн хувийн хэргийг **91.6%** цахимжуулав.

5.7 Эрсдэлийн удирдлага (GRI 2-25)

- 2025 онд Эрсдэлийн удирдлагын бодлогыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулсан бөгөөд 1-р бүсэд бизнесийн нэгжүүд, 2-р бүсэд эрсдэл, комплайнс хариуцсан нэгжүүдийг хамруулсан зохицуулалтыг бий болгов.
- **IFRS 9**-ийг автоматжуулах ажлыг эхлүүлэв.
- Тасралтгүй аудитын хүрээнд нийт 58 шалгуурын хүрээнд баталгаажуулалт хийгддэг бөгөөд нэмэлт 12 шалгуур шинээр нэмж, хяналт, баталгаажуулалтын үр нөлөөг сайжрууллаа.



6. GRI Context Index

Энэхүү тайлан нь **GRI (Global Reporting Initiative)** стандартуудын дагуу боловсруулсан болно. Доорх хүснэгт нь тайлан дахь мэдээллийг GRI үзүүлэлтүүдтэй хэрхэн уялдуулан тайлбарласан, мөн одоогоор боловсруулж буй үзүүлэлтүүдийг харуулж байна.

GRI 2 – Ерөнхий нэмэлт мэдээлэл

GRI Стандарт	Илэрхийлэл / Шаардлага	Тайланд байгаа эсэх	Хуудас / Хэсэг
GRI 2-1	Байгууллагын мэдээлэл	Тийм	Хэсэг 1.1
GRI 2-2	Тайлагналтын хүрээ	Тийм	Хуудас 5
GRI 2-3	Тайлагналтын хугацаа, давтамж	Тийм	Хуудас 5
GRI 2-6	Үйл ажиллагааны тайлбар	Тийм	Хэсэг 1.1
GRI 2-9	ТУЗ-ийн бүтэц	Тийм	Хэсэг 5.1
GRI 2-22	Тогтвортой байдлын стратегийн мэдээлэл	Тийм	Хэсэг 2.1
GRI 2-23	Бодлого ба Амлалтууд	Тийм	Хэсэг 5.3
GRI 2-25	Сөрөг нөлөөллийг засах үйл явц	Хэсэгчлэн	Хэсэг 5.6
GRI 2-29	Оролцогч талуудтай харилцах	Тийм	Хэсэг 1.3

GRI 3 – Тэргүүлэх сэдвүүд

GRI Стандарт	Илэрхийлэл / Шаардлага	Тайланд байгаа эсэх	Хуудас / Хэсэг
GRI 3-1	Тэргүүлэх сэдвүүдийг тодорхойлох үйл явц	Хэсэгчлэн	Хэсэг 2.2
GRI 3-2	Тэргүүлэх сэдвүүдийн жагсаалт	Тийм	Хэсэг 2.2

GRI 200 – Эдийн засаг

GRI Стандарт	Илэрхийлэл / Шаардлага	Тайланд байгаа эсэх	Хуудас / Хэсэг
GRI 201-1	Бий болгосон болон хуваарилсан эдийн засгийн үнэ цэнэ	Хэсэгчлэн	Хэсэг 4.5
GRI 205-2	Авлигын эсрэг бодлогын сургалт	Тийм	Хэсэг 5.3

GRI 300 – Байгаль орчин

GRI Стандарт	Илэрхийлэл / Шаардлага	Тайланд байгаа эсэх	Хуудас / Хэсэг
GRI 301-1	Ашигласан материалын хэмжээ	Хэсэгчлэн	Хэсэг 3.3 (цаас, принтер)
GRI 303-1	Усны хэрэглээ	Хэсэгчлэн	Хэсэг 3.3 (мэдлэг нэмэгдүүлэлт)
GRI 305-1	Score 1 хүлэмжийн хий	Тийм	Хэсэг 3.1 (~7.3 тонн CO ₂)
GRI 305-2	Score 2 хүлэмжийн хий	Тийм	Хэсэг 3.1 (~370.4 тонн CO ₂)
GRI 305-3	Score 3 хүлэмжийн хий	Үгүй	Ирээдүйд нэмэх
GRI 306-1	Хог хаягдлын үүсэлт	Хэсэгчлэн	Хэсэг 3.3

GRI 400 – Нийгэм

GRI Стандарт	Илэрхийлэл / Шаардлага	Тайланд байгаа эсэх	Хуудас / Хэсэг
GRI 401-1	Хүний нөөц	Тийм	Хэсэг 4.1 (шинэ ажилтан 41%)
GRI 403-1	ХМАБ-ын тогтолцоо	Хэсэгчлэн	Хэсэг 4.3
GRI 404-1	Дундаж сургалтын цаг	Тийм	Хэсэг 4.1
GRI 405-1	Удирдлагын баг дахь олон янз байдал	Тийм	Хэсэг 4.1, 5.2
GRI 417-1	Бүтээгдэхүүний мэдээлэл	Хэсэгчлэн	Хэсэг 4.4, 4.5
GRI 418-1	Хувийн мэдээллийн зөрчил	Хэсэгчлэн	Хэсэг 5.6

GRI FS – Санхүүгийн үйлчилгээний салбарын тусгай ҮЗҮҮЛЭЛТҮҮД

GRI Стандарт	Илэрхийлэл / Шаардлага	Тайланд байгаа эсэх	Хуудас / Хэсэг
GRI FS7	Нийгмийн нөлөөтэй бүтээгдэхүүний хэмжээ	Тийм	Хэсэг 4.4, 4.5
GRI FS8	Байгаль орчны ашиг тустай бүтээгдэхүүн	Тийм	Хэсэг 4.5
GRI FS13	Санхүүгийн хүртээмжгүй бүлгийн хамрагдалт	Тийм	Хэсэг 4.4
GRI FS14	Тусгай хэрэгцээт хүмүүст санхүүгийн хандах боломж	Хэсэгчлэн	Хэсэг 4.4



БОГД БАНК

Тогтвортой хөгжлийн тайлан
2025 он

www.bogdbank.com

